

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/78/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512
Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор : Д.Эрдэнэчимэг
Утас: 261740
Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261740
Цахим хаяг: nyamsurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/735
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,452.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа эсвэл нийтээр материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой дараах материаллаг гүйлгээнүүд хийгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 93 дугаар тогтоолоор Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-аас Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд байрлах, шатах тослох материал түгээгүүрийн газар, агуулах, шатахуун түгээх станцын зориулалттай, 59,648 м.кв талбай бүхий 5,344.4 сая төгрөгийн балансын үнэтэй газар, 659.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 17 төрлийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэн
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоож балансаас баланст шилжүүлэх тухай" 50 дугаар тогтоолоор 6,204.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4,667.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 61 нэрийн хөрөнгийг Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанаас Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-д шилжүүлсэн
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 438 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэгжээс хүлээлгэн өгсөн 16 нэрийн, барилга байгууламжийн үнийг 9,985.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож, бүртгэсэн

Аудитын гол асуудал

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2023 оны “Тушаалын хавсралтыг хүчингүй болгож, шинэчлэн батлах тухай” А/398 дугаар тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцийг 6 газар, 9 хэлтэс, харьяа 16 салбар, 17 орон нутгийн нисэх буудалтай, нийт 2090 орон тоотойгоор баталсан байна.

Тайлант онд үйл ажиллагааны орлогоос 13,457.1 сая төгрөг, Иргэний нисэхийн ерөнхий газраас 127,134.5 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 140,591.6 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 18,003.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 114,629.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 146,034.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлж, 92 арга хэмжээний хэрэгжилт 89.0 хувьтай байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,473,157,115.07	1,041,583,632.27
1.1.2	Дансны авлага	7,427,251,459.41	5,893,015,667.58
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	49,262,560.97	1,376,264,214.29
1.1.4	Бусад авлага	1,317,967,084.41	931,639,213.43
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	16,323,647,757.28	16,752,903,757.34
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	470,784,526.77	476,077,968.86
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	5,547,500.00	6,047,500.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,067,618,003.92	26,477,531,953.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	184,326,444,955.36	163,499,532,526.51
1.2.2	Биет бус хөрөнгө	372,956,718,602.51	376,568,750,148.38
1.2.3	Дуусаагүй барилга	49,014,000.73	114,812,046.18
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,006,151,866.62	524,207,380.95
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	559,338,329,425.23	540,707,302,102.02
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	586,405,947,429.15	567,184,834,055.79
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
2.1.	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	2,019,907.64	133,857,501.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	1,311,195,106.40	98,565,632.01
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	114,166.21
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	22,812,134.67	7,547,011.33
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	445,883,732.52	180,887,278.95
2.1.1.12	Системийн өглөг	-	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,781,910,881.24	420,971,589.50
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.4	Урьдчилж орсон орлого - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	5,277,717,725.49	4,686,696,741.60
2.1.2.5	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,277,717,725.49	4,686,696,741.60
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,059,628,606.73	5,107,668,331.10
2.3	Эздийн өмч	440,657,003,518.23	412,368,205,895.46
2.3.1	Өмч: - төрийн	388,068,387,740.00	371,685,762,540.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	52,588,615,778.23	40,682,443,355.46
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг	1,651,888,249.81	1,453,098,485.77
2.3.9	Хуримтлагдсан ашиг	137,037,427,054.38	148,255,861,343.46
	Эздийн өмчийн дүн	579,346,318,822.42	562,077,165,724.69
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	586,405,947,429.15	567,184,834,055.79

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	11,838,116,391.27	15,428,683,547.08
2	Борлуулалтын өртөг	116,977,275,243.95	136,668,029,525.39
3	Нийт ашиг (алдагдал)	(105,139,158,852.68)	(121,239,345,978.31)
4	Түрээсийн орлого	441,393,012.38	644,780,500.03
5	Хүүгийн орлого	-	26,543,182.98
8	Бусад орлого	290,044,055,685.44	223,575,170,966.25
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,697,979,402.26	1,528,461,432.67
12	Бусад зардал	184,780,574,860.59	122,922,840,290.76
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	21,211,002.79	(24,833,264.28)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(79,839,200.46)	(941,757,816.89)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,190,892,615.37)	(22,410,744,133.65)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,190,892,615.37)	(22,410,744,133.65)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,190,892,615.37)	(22,410,744,133.65)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(1,190,892,615.37)	(22,410,744,133.65)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	168,282,686,956.61	188,748,848,866.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,369,770,152.94	16,684,853,581.18
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	245,833,100.25	40,974,068.20
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	150,844,647,110.65	168,270,118,276.93
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	3,655,644,793.17	1,766,381,413.29
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	1,172,287,747.69	1,986,521,526.83
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	169,406,214,143.21	188,883,521,131.21
1.2.1	Ажиллагчдад төлсөн	61,175,948,416.63	69,431,236,779.43
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,794,701,666.40	12,196,319,159.27
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,814,201,984.76	4,394,265,830.47
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,643,910,567.81	4,450,394,263.28
1.2.5	Хүүгийн төлбөрт төлсөн	-	2,633,859.41
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,368,637,639.61	4,004,580,468.99
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	13,185,998,906.12	17,159,127,249.39
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	148,490,651.32	146,050,767.13
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	66,510,658,805.10	73,663,783,867.01
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	1,763,665,505.46	3,435,128,886.83
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,118,031,238.51)	(134,672,264.78)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	26,543,182.98
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	26,543,182.98
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	61,876,300.00	323,444,401.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	61,876,300.00	323,444,401.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,876,300.00)	(296,901,218.02)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,179,907,538.51)	(431,573,482.80)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,653,064,653.58	1,473,157,115.07
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,473,157,115.07	1,041,583,632.27

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д / Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	380,558,152,900.00	30,066,263,133.29	2,001,019,621.81	138,229,024,215.20	550,854,459,870.30
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,190,892,615.37)	(1,190,892,615.37)
3	Өмчид гарсан өөрчлөлт	7,510,234,840.00	22,522,352,644.94	(349,131,372.00)	(704,545.45)	29,682,751,567.49
4	2022 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	388,068,387,740.00	52,588,615,778.23	1,651,888,249.81	137,037,427,054.38	579,346,318,822.42
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(22,410,744,133.65)	(22,410,744,133.65)
6	Өмчид гаргасан өөрчлөлт	(16,382,625,200.00)	(11,906,172,422.77)	(198,789,764.04)	33,629,178,422.72	5,141,591,035.92
7	2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	371,685,762,540.00	40,682,443,355.46	1,453,098,485.77	148,255,861,343.46	562,077,165,724.69

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	Зорчигчийн тоо	хүн	952,765.0	1,500,000.0	1,731,291.0	(231,291.0)	115.4
	Олон улс	хүн	618,960.0	1,050,000.0	1,312,167.0	(262,167.0)	125.0
	Орон нутаг	хүн	333,805.0	450,000.0	419,124.0	30,876.0	93.1
	Ачаа	тонн	11,654.0		7,928.3		
	Олон улс	тонн	11,634.0		7,913.0		
	Орон нутаг	тонн	20.0		15.3		
	Шуудан	тонн	1,239.0	20,000.0	645.2	11,426.5	42.9
	Олон улс	тонн	1,235.0		642.6		
	Орон нутаг	тонн	4.0		2.6		
	Нийт буулт, хөөрөлт	тоо	14,153.0	26,328.0	19,964.0	6,364.0	75.8
Олон улсын буулт, хөөрөлт	тоо	5,334.0	13,345.0	9,654.0	3,691.0	72.3	
Орон нутгийн буулт, хөөрөлт	тоо	8,819.0	12,983.0	10,310.0	2,673.0	79.4	
2	Нийт орлого	сая.төг	13,129.4	13,457.1	16,943.2	(3,486.0)	125.9
	Үүнээс буулт, хөөрөлтийн орлого	сая.төг	136.1	73.5	469.1	(395.6)	638.3
	Зорчигч үйлчилгээний орлого	сая.төг	52.3	33.4	101.0	(67.6)	302.7
	Бусад орлого	сая.төг	12,941.0	13,350.3	16,373.1	(3,022.8)	122.6
3	Нийт зардал	сая.төг	110,653.9	140,591.6	117,313.3	23,278.3	83.4
	Үүнээс: Цалин, нэмэгдэл урамшуулал	сая.төг	64,668.2	77,765.3	69,995.7	7,769.6	90.0
	Ажил олгогчоос төлөх НДШ	сая.төг	8,288.3	9,888.7	9,002.0	886.6	91.0
	Ашиглалтын зардал	сая.төг	3,032.2	4,836.7	3,318.7	1,518.0	68.6
	Хангамж, бараа материалын зардал	сая.төг	5,083.4	6,573.9	5,001.0	1,572.9	76.1
	Нормативд зардал	сая.төг	129.4				
	Эд хогшил, урсгал засварын зардал	сая.төг	3,304.4	6,262.8	3,396.4	2,866.4	54.2
	Хөдөлмөр хамгааллын зардал	сая.төг	344.2	1,116.8	762.2	354.6	68.2
	Томиллолт, зочны зардал	сая.төг	588.9	870.6	805.3	65.2	92.5
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	сая.төг	17,317.7	23,293.2	17,628.5	5,664.8	75.7
	Бусад зардал	сая.төг	1,743.0	2,353.4	1,296.4	1,057.0	55.1
	Урсгал шилжүүлэг	сая.төг	6,154.0	7,630.3	6,107.0	1,523.2	80.0

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 552.1 сая төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад 536.9 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 15.2 сая төгрөгийн 3 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 2,452.9 сая төгрөгийн 21 зөрчил² илэрснээс, 107.6 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 2,272.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 73.2 сая төгрөгийн 11 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 2,452.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 1,460.3 сая төгрөгөөс хэтэрсэн байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Иргэний нисэхийн үндэсний төв	Санхүүгийн байдлын тайланд эхний үлдэгдэл 5.5 сая төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны гүйцэтгэл 5.4 сая төгрөгөөр, орлогын дэлгэрэнгүй тайлангийн өмнөх оны гүйцэтгэлийг 521.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.	1	532,816.0			1	532,816.0				
2	Ховд нисэх буудал	Зөвлөх үйлчилгээний төлбөрийг гэрээ байгуулан шилжүүлсэн тухайн байгууллага нь гэрээний дагуу үйлчилгээ үзүүлээгүйтэй холбоотой авлага тусгаагүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	9,400.0							1	9,400.0
		Тайланд онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас нийлүүлээгүй 7 тонн нүүрсийг хүлээн аваагүй, бараа материалын тайланд орлогоор бүртгэсэн	1	5,600.0	-	-	-	-	-	-	-	1
3	Гурвансайхан нисэх буудал	2 ажилтанд 0.2 сая төгрөгийн үр дүнгийн нэмэгдлийг илүү олгосон.	1	184.3							1	184.3
4	Говь-Алтай нисэх буудал	Тайланд авлагыг 1,1 сая төгрөгөөр илүү тайлагнасан.	1	1,125.0			1	1,125.0				
		Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн	1	3,004.3			1	3,004.3				

		татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 3.0 сая төгрөгийг дутуу шивсэн.										
Нийт алдаа			6	552,129.6			3	536,945.3	-	-	3	15,184.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Шалгагдагч байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИНУТ	ИНУТ нь Шинэ нисэх буудлын дэргэд байрлах "А кемп" байгууламжийн төв оффисын 7 байрыг түрээслүүлэн 235.5 сая төгрөгийн түрээсийн орлого олсон боловч 40.0 хувь буюу 94.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	94,212.2	1	94,212.2						
Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах алба	Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах алба нь спорт цогцолборын барилгын спортын заал талбайг ИНУТ-ийн даргын 2022 оны А/139 дүгээр тушаалаар баталсан тарифаар тооцон 20.9 сая төгрөгийн түрээсийн орлого бүрдүүлснээс, орлогын 40.0 хувь буюу 8.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	8,300.0	1	8,300.0						
ИНУТ	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж хоолны зардалд 1.6 сая төгрөг, чанадаг кофе худалдан авахад 1.4 сая төгрөг, гэрэл зураг авах ур чадварыг нэмэгдүүлэх сэдэвт сургалтыг Жаргалант амралтад зохион байгуулахад 1.7 сая төгрөг нийт 4.7 сая төгрөгийн үр ашиггүй, зориулалт бус зардал гаргасан байна.	1	4,735.0	1	4,735.0						
ИНУТ	Иргэний нисэхийн үндэсний төв болон түүний харьяа салбаруудад бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтээр алба нэгжийн хөрөнгийг салгаж бүртгэсэнтэй холбоотой нийт 390 ширхэг, 534.0 сая төгрөгийн хөрөнгө дутуу бүртгэсэн, мөн 381 ширхэг хөрөнгө бүртгэлгүй байна.	1	534,621.4			1	534,621.4				

ИНУТ	ИНУТ-ийн 2005-2019 онуудад үүссэн 37 иргэн, хуулийн этгээдтэй холбогдох 810.4 сая төгрөгийн он удаан жил болсон авлагыг барагдуулаагүй байна.	1	810,414.6			1	810,414.6		
ИНУТ	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 18.3 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой контент бэлтгэх, форум зохион байгуулахад зарцуулсан.	1	18,300.0			1	18,300.0		
ИНУТ	ИНЕГ даргын 2023.12.26-ны өдрийн Б-269 тоот тушаалын дагуу бүтцийн шинэчлэлт хийгдэж байгаатай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуулийн орон тоо нь хасагдсан үндэслэлээр ажилтнуудад 5-36 хүртэл сарын тэтгэмжийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна. /2023 онд 6 ажилтанд 507.8 сая төгрөг олгосон байна/	1	507,837.6			1	507,837.6		
Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Шатахуун хангамжийн алба	Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Шатахуун хангалтын алба нь нэр бүхий 2 компанитай "Агаарын хөлгийн ТС-1 төрлийн шатахууныг усыг усаар буцаан өгөх нөхцөлтэйгөөр олгох гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээнд зааснаар хугацаандаа шатахуунаа буцаан олгоогүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн тонн бүрд хоног тутам 0.5 хувийн алданги тооцохоор заасан боловч гэрээг дүгнэн, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, хугацаа хэтрүүлсэн хоногт 150 тонн буюу 323.7 сая төгрөгийн шатахууныг гаргуулан авч, нөөцийн саванд хадгалаагүй байна.	1	323,713.5			1	323,713.5		

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Шатахуун хангамжийн алба	Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Шатахуун хангамжийн албанд хяналтын тооллого хийхэд тооллогоор 51 тн шатахуун илүү байгаагаас зөвшөөрөгдөх алдааг тооцсон дүнгээр /35.7 тн/ шатахуун илүү байна. Тус албаны шатахууны үлдэгдэлд 2023 оны 4 дүгээр сараас 12 дугаар саруудад нийт 7 удаагийн тооллого хийсэн боловч шатахууны тооцоог тухай бүр хийж шийдвэрлээгүй байна. Мөн шатахууны агуулахын /201, 202, 203, 204/ саваар тус тусад нь бүртгээгүй, агуулахын бүртгэл хангалтгүй байна.	1	77,173.3			1	77,173.3		
Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах алба	Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Спорт цогцолборын 5,178.7 сая төгрөгийн өртөгтэй 2023 оны 5 сард ашиглалтад оруулан ашиглаж байгаа боловч тус барилгыг бүртгэлд тусгаагүй, тухайн барилгын баталгаат хугацаанд гарсан засварын зардлыг гүйцэтгэгч ӨВМТХ ХХК-аар гаргуулахаар 2023 онд 10-20/61 тоот, 10-20/76 тоот, 10-20/88 дугаар албан бичгээр хандсан боловч засварын ажил хийгдээгүй байна.	1	-					1	-
Буянт-Ухаа олон улсын нисэх буудал	Буянт-Ухаа олон улсын нисэх буудал нь өөрийн эзэмшлийн 23 м.кв талбайг түрээслүүлэхдээ Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын баталсан "Буянт -Ухаа олон улсын нисэх буудлын үзүүлэх Иргэний нисэхийн зохицуулалтгүй үйлчилгээний хураамж"-ийн хэмжээнээс сарын түрээсийг бууруулан 5.5 сая төгрөгийн түрээсийн орлого дутуу тооцож гэрээ байгуулсан байна	1	5,520.0					1	5,520.0
ИНУТ	Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж зэрэг 934 нэр төрлийн 5,130.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-

Газрын тусгай үйлчилгээ шатахуун хангалтын алба	Газрын тусгай үйлчилгээ шатахуун хангалтын алба нь шатахууны тооцооны баримтад үйлчилгээний 142 жолооч нартай шатахууны тооцоо хийхдээ тооцооны хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, 9.3 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.	1	9,338.7					1	9,338.7
ИНУТ	Татваруудын ногдлын үлдэгдлийг СБТ болон татварын тодорхойлолтоор зэрэгцүүлэн тулгахад зөрүүтэй, татварын системд татварын ногдлоо тулгаж баталгаажуулаагүй байна. Тайлант онд 386 татварын нэхэмжлэлийн 567.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж залруулаагүй, татварын 32 нэхэмжлэлд ногдуулсан 35.2 сая төгрөгийн татварын орлогыг өглөгөөр тусган, татварын орлогын дансанд төвлөрүүлээгүй байна.	1	35,020.5					1	35,020.5
ИНУТ	ИНЕГ-ын даргын 2023 оны А/398 дугаар тушаалаар ИНУТ-ийн бүтэц, орон тоог шинэчлэн баталж 16 нэгжтэй, нийт 2086 орон тоотой байхаар баталсан байна. Бүтэц, орон тоог шинэчлэн батлах талаар судалгаа, тооцоолол хангалтгүй хийсэн байна. Тухайлбал: - 112 ажилтны орон тоог хасаж, шинээр 131 орон тоо нэмэгдсэн - Төлөвлөлтийн чиг үүргийг санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн хэлтэс, бизнес хөгжил төлөвлөлтийн хэлтэс гэж 2 хувааснаар нэгдсэн төлөвлөлт хийх боломжгүй болсон - нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, аж ахуй хангамжийн хэлтэс гэж тусад нь баталснаар нягтлан бодогч эд хариуцагчийн хяналт тодорхойгүй болсон - төвийн салбар, нэгжүүдэд байсан удирдах ажилтан 92 байснаас 110 болж нэмэгдсэн, орон нутгийн нисэх буудлуудад 15 удирдах ажилтан байснаас 32 болж 16 менежерийн орон тоо нэмэгдсэн байна.	1	-					1	-
Нийт		15	2,429,186.8	3	107,247.2	6	2,272,060.4	6	49,879.2
Говь-Алтай нисэх буудал	Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.4 сая төгрөгийг илүү олгосон.	1	366.8	1	366.8				

Дорнод нисэх буудал	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	1	-					1	-
Хөвсгөл нисэх буудал	Санхүүгийн тайланд бүртгэлтэй Hundai. County-Автобус УБИ 69-78, Цас үлээгч Урал 375 УБЯ 10-97, Камаз Ко829, УББ 54-04 гэсэн тээврийн хэрэгслүүд хаягийн өөрчлөлт хийлгээгүй байгаа учраас бүртгэлгүй, ачаа тээшний туузан дамжуулагч машин, хадуур тармууртай трактор гэрчилгээгүй, улсын дугааргүй ашиглагдаж байна.	1	-					1	-
	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3.0 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг GPU төхөөрөмж, 20.2 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг дизель генератор биетээр байхгүй байна.	1	23,211.0					1	23,211.0
	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 13 нэр төрлийн (анхны өртөг 330.9 сая төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.	1	-					1	-
	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар авлага, өглөггүй байгаа боловч санхүүгийн байдлын тайлан дахь Нийгмийн даатгалын өглөг дансанд 0.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	114.2					1	114.2
Дүн		6	23,692.0	1	366.8	0	-	5	23,325.2
Нийт дүн		21	2,452,878.8	4	107,614.0	6	2,272,060.4	11	73,204.4

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3 зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Шалгагдагч байгуулл-агын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
			Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Буянт Ухаа Олон улсын нисэх буудал	Буянт Ухаа Олон улсын нисэх буудлын хамгаалалтын талбай дахь тусгай хэрэгцээний газартай хил нийлүүлэн /1781310951/ нэгж талбарын дугаартай газрыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д орон сууцны ашиглалтын төрлөөр эзэмших эрхтэйгээр олгосон, мөн хамгаалалтын хашааны 3 метрийн зайд Ай ти зон ХХК, Ситибылдинг ХХК, Бүрэн Хайрхан Ээж Трэйд ХХК, Иргэн ХХК, Буянт Бумба Эрдэнэ ХХК, Могоул групп ХХК, Зэмэдү ХХК зэрэг компаниуд барилга байгууламж болон хашаа тулган барьж байгаа нь Аэродромын хөдөлгөөний бүсэд мал амьтан, гаднын этгээд санаатай болон санамсаргүйгээр нэвтрэх гэх мэт нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаанд нөлөөлж нисэх буудлын үйл ажиллагаанд хүндрэл учруулах эрсдэлтэй байна.	1	-					1	-
ИНУТ	Иргэний нисэхийн үндэсний төвийн төсвийг захиран зарцуулах эрхийг шилжүүлэх шийдвэр гараагүйгээс тус байгууллагын төсвийг Иргэний нисэхийн ерөнхий газраас зарцуулж байгаа нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт алдагдах эрсдэл үүссэн байна.	1	-					1	-
ИНУТ	Тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг олгохдоо Хамтын гэрээ болон ИНЕГ-ын даргын тушаалыг үндэслэн дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээгээр тооцож өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 53 ажилтанд 4,782.5 сая төгрөг олгосон нь үндсэн цалингаас тооцсон дүнгээс 2,102.2 сая төгрөгөөр буюу 82.0 хувиар өндөр байна.	1	2,102,196.2					1	2,102,196.2
ИНУТ	Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэхдээ ажилласан хугацаа, ажлын бүтээмжийг харгалзан үнэлэх үзүүлэлт тодорхойгүй, үр дүнгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосноос 2023 онд шинээр орсон 88 ажилтныг түүвэрлэн үзэхэд сар бүр 40.0 хувийн нэмэгдэл тооцон 179.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	-					1	-

ИНУТ	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 1516 мэдээнээс 1506 мэдээг хугацаанд нь мэдээлж 10 мэдээ хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-	-	-	-	1	-
ИНУТ	Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны А/80 дугаар тушаалаар баталсан агаарын тээврийн үйлчилгээний шинэчлэн баталсан тарифыг мөрдөөгүйгээс орон нутгийн нисэх буудлуудын орлогыг нэмэгдүүлэх, алдагдал бууруулах боломжийг алдсан байна.	1	-	-	-	-	1	-
Нийцлийн асуудлын дүн		6	2,102,196.2	-	-	-	6	2,102,196.2